



ЗӨВЛӨХ-Д

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.09.11 № 03/2779
танай _____-ны № _____-т

Бичиг баримт ирүүлэх тухай

Үндэсний аудитын газраас “Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн “Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км авто зам барих” төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, баригдсан авто замын техник ашиглалтын түвшин, чанар байдалд дүгнэлт гаргах” зөвлөх үйлчилгээг үзүүлэх гүйцэтгэгчийг гэрээ шууд байгуулах аргаар сонгон шалгаруулах гэж байгаа тул дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ үү. Үүнд:

- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх хүсэлт;
- Жишиг маягийн дагуу үнийн болон техникийн санал, зөвлөхийн танилцуулга;
- Санал болгож буй мэргэжилтний намтар(CV)-ын жишиг маягтын дагуу;
- Сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, иргэний үнэмлэхийн хуулбар;
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аргачлал;
- Ажлын даалгаврын 10-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6-д заасны дагуу хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй тухай бичиг;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;
- Авто зам, гүүрийн барилга байгууламжийн гүйцэтгэл нь ажлын тоо хэмжээ, баригдсан авто замын техник ашиглалтын түвшин, чанар байдалд дүгнэлт гаргасан төсөл арга хэмжээний жагсаалт /зөвлөхийн бие дааж хийсэн болон хамтран оролцож хийсэн ажлын жагсаалт/ тус тус ирүүлнэ үү.

Тендертэй холбоотой нэмэлт мэдээллийг 2020 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минут хүртэл авах бөгөөд мэдүүлгээ Үндэсний аудитын газарт 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 30 минутын дотор ирүүлнэ үү.

Хавсралт 10 хуудастай.

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр, 04 дүгээр давхар, 403 тоот өрөө.
Үндэсний аудитын газар,
Утас: 11-329870

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ц.ГАНБОЛД

9000 \\10.10.10.20\Bichig_KheregiYawsan_Bichig\2020\09\11TG1.Docx
0010120336

001054577

1. ТЕХНИКИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай [он, сар, өдөр]-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид [Зөвлөхийн үйлчилгээний нэр] үзүүлэхээр санал болгож байна. Бид техникийн болон санхүүгийн саналаа тус тусад нь битүүмжилсэн дугтуйд хийж үүгээр хүргүүлж байна.

Саналын хүчинтэй байх хугацаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [30] хоногийн дотор буюу [он, сар, өдөр]-аас өмнө хэлэлцээр хийгдэх бол санал болгож буй ажилтнуудад үндэслэж оролцоно. Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

2. ЗӨВЛӨХИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгууллагын чадварыг харуулж чадах сүүлийн 5 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу танай байгууллагын дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү.

Зөвлөх үйлчилгээний нэр:		Улсын нэр:
Байршил:		Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):
Захиалагчийн нэр:		Ажилтны тоо:
Хаяг:		Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүнсарын тоо:
Эхэлсэн он сар өдөр:	Дууссан он сар өдөр:	Зөвлөх үйлчилгээний өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:
Түншлэн ажилласан зөвлөхийн нэр (хэрэв байвал):		Түншлэн ажилласан зөвлөхийн ажилтнуудын ажилласан сарын тоо:
Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд:		
Төслийн талаарх товч танилцуулга:		
Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:		

Зөвлөх компанийн нэр: _____

3. САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: _____
Байгууллагын нэр: _____
Мэргэжилтний нэр: _____
Мэргэжил: _____
Төрсөн он, сар, өдөр: _____
Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____
Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____
Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____

Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

4. АЖЛЫН ХУВААРЬ

А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

	<i>[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]</i>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үйл ажиллагаа (ажлууд)												

В. Ажлыг дуусгаж тайлан өгөх

Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	
2. Явцын тайлан (а) 1 дэх тайлан (б) 2 дахь тайлан	
3. Тайлангийн төсөл	
4. Эцсийн тайлан	

5. САНХҮҮГИЙН САНАЛ ИРҮҮЛЭХ МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

Танай **[он, сар, өдөр]**-ийн зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичиг болон өөрсдийн энэ саналын дагуу бид **[зөвлөхийн үйлчилгээний нэр]**-г **[санхүүгийн саналын дүнг тоогоор болон үсгээр бичнэ]** төгрөгөөр гүйцэтгэхээр санал болгож байна. Энэ үнэд **[татварын дүнг тоогоор болон үсгээр]** төгрөгийн дотоодын татвар, хураамж орсон болно.

Саналын хүчинтэй байх хугацаа нь санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **[30]** хоногт буюу **[он, сар, өдөр]**-аас өмнө хийгдэх гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд бидний санхүүгийн санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Хүндэтгэсэн,


Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Зөвлөх үйлчилгээний байгууллагын нэр:

Хаяг:

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕССЫН БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ ТӨРЛӨӨР ХЭРЭГЖСЭН “УЛААНБААТАР ДАРХАНЫ ЗАМААС АГЛАГ БҮТЭЭЛИЙН ХИЙД ЧИГЛЭЛД 6.2 КМ” ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ БАРИХ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ЧАНАР, БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2020 оны 02 дугаар сарын
07-ний өдөр

Дугаар УАН-2020/004А-2 Улаанбаатар хот

АЖЛЫН ЗОРИЛТ:

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн “Улаанбаатар-Дарханы замаас Аглаг бүтээлийн хийд чиглэл”-ийн 6.2 км хатуу хучилттай авто замын барилга байгууламжийн ажлын тоо хэмжээ, чанар байдал нь Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдсон зарчим, шаардлага, олон нийтийн эрх ашиг, технологи арга туршлага, бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилт оршино.

1. ОРШИЛ:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 7 дахь заалтад “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд “хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах” гэж заасан.

2. ҮНДЭСЛЭЛ:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

3. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Засгийн газрын “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 2013 оны 317 дугаар тогтоолд 2015 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 306 дугаар тогтоолоор оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Улаанбаатар-Дарханы авто замаас Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км замыг концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Засгийн газрын 2015 оны 306 дугаар тогтоолоор “Улаанбаатар-Дарханы авто замаас Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км зам барих” төслийг концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлж, төслийн гүйцэтгэгчийг уралдаант шалгаруулалт явуулах байдлаар сонгохоор шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2015 оны 334 дүгээр тогтоолоор Аглаг бүтээлийн хийд хүртэлх 7 км авто замын ажлын “уралдаант шалгаруулалт явуулах” гэснийг “шууд гэрээ байгуулах” гэж өөрчилсөн байна.

Засгийн газрын 2015 оны “Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” 379 дүгээр тогтоолоор Үндэсний хөгжлийн газар болон “Хансуун зам” ХХК-ийн хооронд 2015 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр 6,952.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар-Дарханы авто замаас Аглаг бүтээлийн хийд чиглэлд 6.2 км хатуу хучилттай авто зам” барих төслийн концессын гэрээ байгуулагдсан байна.

Авто замын ажлыг ашиглалтад хүлээн авах комисс 2019 оны 9 дүгээр сард ажиллаж 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 10/5/19 дугаартай “Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийн дүгнэлт” гаргаж “Улаанбаатар Дарханы авто замаас Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км зам”-ыг байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

4. АВТО ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛБАР

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжсэн “Улаанбаатар-Дарханы замаас Аглаг бүтээлийн хийд чиглэл”-ийн 6.2 км хатуу хучилттай авто замын барилга байгууламжийн ажлын тоо хэмжээ, баригдсан авто замын техник ашиглалтын түвшин, чанар байдалд дүгнэлт гаргах ажлыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Авто зам, гүүрийн барилга байгууламжийн гүйцэтгэл нь батлагдсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах;
2. Авто зам, гүүрэн байгууламж барих үе шатны дараах ажлуудад дүгнэлт гаргах;
 - шороон далан барих ажил
 - хиймэл байгууламж барих ажил
 - суурийн ажил
 - хучилтын ажил
 - хөвөөний ажил
 - авто замын тоноглол, тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажлын гүйцэтгэлийг нягталж, дүгнэлт гаргах;
3. Авто зам, гүүрэн байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох дараах ажлуудад дүгнэлт гаргах;
 - геометр хэмжээс
 - хучилтын гадаргуугийн тэгш бус байдал
 - хучилтын зузаан
 - асфальт бетоны хольцын орцын шинжилгээ

- битумын шинжилгээний дүгнэлт
- хучилтын дундаж нягтралт
- төмөр бетоны марк
- гулсалтын эсэргүүцэл
- хучилтын ачаа-даацын харьцааг тус тус тодорхойлж дүгнэлт гаргах

4. Авто замын барилга байгууламжийн угсралтын үе шатны ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгах;
5. Авто замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;
6. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийн хувьд батлагдаж, хянагдсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, барилга угсралтын явцад төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.

5.АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Ажлын зорилтын хүрээнд Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам болон зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, концесс эзэмшигчид, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж зэрэг байгууллагуудаас төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой шаардлагатай баримт материалыг ҮАГ-ын аудитын баг гаргуулна.

Бэлтгэгдсэн ажлын баримт материалд тулгуурлан үндсэн зорилгыг хэрэгжүүлэх болон баримтат нотлох зүйлсэд үндэслэн төслийн байршил дээр үзлэг шалгалт хийх, ажлын тоо хэмжээг тулгах, дүн шинжилгээ, давтан тооцоолол хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

6.ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Концессын гэрээгээр хэрэгжиж байгаа авто зам, гүүрийн барилга байгууламжийн төслийн ажлын гүйцэтгэл холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан эсэх, техникийн шаардлагын дагуу баригдсан эсэх, техник ашиглалтын түвшин чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж мэргэжлийн дүгнэлт гаргахын зэрэгцээ, дүгнэлт гаргах үйл ажиллагааны үр дүнг тусгасан шинжээчийн тайлан бичнэ.

7.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх хуулийн этгээд болон шинжээчид нь Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын Үйлдвэр, дэд бүтцийн салбарын аудитын баг бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд, шинжээчид нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлж захиалагч (Үндэсний аудитын газар)-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авах зэргээр ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад илэрсэн, хэрэгжүүлэх явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

8.АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Эхлэх хугацаа: 2020 оны дүгээр сарын...-ны өдөр
Дуусах хугацаа: 2020 оны..... дугаар сарын...-ны өдөр

9.ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, Санхүүжүүлэгч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах гурван талын гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана. Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээ байгуулагдсаны дараа гэрээт ажлын урьдчилгаа төлбөрт гэрээний үнийн дүнгийн 40 хүртэл хувийг олгох ба үлдэгдэл санхүүжилтийг 2 хувааж олгоно.

Үлдэгдэл санхүүжилтийн эхний хэсэг буюу гэрээний үнийн дүнгийн 40 хүртэл хувийг гэрээт ажлын тайланг Захиалагч тал хянаж, хүлээн авсны дараа олгох бол үлдэгдэл санхүүжилтийн сүүлийн хэсэг болох гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх төлбөрийг концессын төслүүдэд УАГ-аас гаргах дүгнэлт, тайлан бэлтгэгдэж, УИХ болон бусад талуудад хүргүүлсний дараа олгоно.

10.ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Шинжээчийн баг нь дараах шаардлагыг хангасан боловсон хүчний бүрэлдэхүүнтэй байна.

Авто замын инженер мэргэжилтэй

- Авто замын барилга угсралтын чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй 2 хүн;
- Авто замын болон хиймэл байгууламжийн /гүүр, ус зайлуулах хоолой/ ажлын гүйцэтгэлд хяналт хийх, магадлал хийх эрхтэй, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин 1 хүн.

Шинжээчийн баг нь дээрх шаардлагыг хангасан ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байна.

Нууцлал: Шинжээч нь ажлын явцад олж авсан болон мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд хийж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай гүйцэтгэнэ.

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С. ОЮУНГЭРЭЛ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЕНЕЖЕР



Н.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.САРУУЛ

Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР



Б.БОЛОРМАА